



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

### Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.4, 47 дугаар зүйлийн 47.1, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.17 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 29 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ногдол ашгийн бодлого"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн 2023 оны жилийн эцсийн аудитын өмнөх санхүүгийн тайлангийн татварын дараах цэвэр ашиг болох 8,699,165,845 төгрөгөөс нэгж хувьцаанд 12 төгрөг 41 мөнгө буюу нийт 4,349,252,518.99 төгрөгийн ногдол ашгийг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

3. Ногдол ашиг хуваарилж дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор ногдол ашиг хуваарилалтын тайланг гаргаж эрх бүхий байгууллагад хүргүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.

5. Энэхүү тогтоолыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийт хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Тэмүүжин)-д даалгасугай.

6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1524010017